

## ГЛОБАЛЧЛАЛ: ЧИГ ХАНДЛАГА, ҮЙЛ ЯВЦ

*Ц.Баатар\**

Глобалчлалын шинж төрх бүрэн дүүрэн илэрч гарах хараахан болоогүй байгаа хэдий ч уг үйл явцын талаар эрдэмтэн мэргэд, үйлдвэр худалдааны эзэд, улс төрийн болон удирдах бүлгийнхэн хоорондоо халуухан мэтгэлцээн өрнүүлсээр байна.

Глобалчлалыг эсэргүүцэгчид террорист халдлага болон дэлхий дахины эдийн засгийн хөгжлийн өнөөгийн зогсонги байдлыг бүхэлд нь глобалчлалд нялзааж байна.

Дэлхийн эдийн засгийн хөдөлгүүрийн үүрэг гүйцэтгэдэг орнуудын эдийн засаг зогсонги байдалд орлоо гэж үзэх нь харьцангуй ойлголт. Учир нь 2000 оны хавраас эхэлсэн өндөр технологийн хөгжлийн хурдац дэлхий дахины хөрөнгийн захын хувьцааны үнийг эрс унагахад хүргэсэн. Нөгөө талаас хөгжингүй орнууд өнөөгийн байдлаа өмнөх жилүүдийнхээ өндөр хурдацтай эдийн засгийн өсөлт болон дэлхийн интеграцчлалтай харьцуулж “зогсонги” байдалд орлоо гэж үзэж байгаа юм.

Дэлхийн улс орнууд улам бүр интеграцчлагдах тэр хэр хэмжээгээр илүү тогтвортой хөгжих нөхцөл бүрдэнэ гэж ихэнхи судлаачид үздэг.

2001 оны Нобелийн шагналт, Дэлхийн Банкны эдийн засагч асан Америкийн нэртэй эдийн засагч, глобалчлалыг зартай эсэргүүцэгч Жозеф Стиглиц “хил хязгааргүй болсон өнөөгийн дэлхий ертөнцөд бараа, үйлчилгээ чөлөөтэй урсаж байгаагийн нэгэн адил бусад сөрөг зүйлүүд ч чөлөөтэй урсаж байна” гэсэн байдаг. Үнэхээр өнөөдөр глобалчлал нь өвчин эмгэгээс эхлэн үзэл бодол хүртэлх олон зүйл хил дамнан тархаж буй торон сүлжээ үүсгэж байгаа үйл явц билээ.

Глобалчлалын талаархи мэтгэлцээнд хөндөгдөхгүй орхигдоод байгаа нэг зүйл бол түүний өнөөгийн хүрсэн түвшин, шалгуур үзүүлэлт, үнэлэмжийн тухай асуудал юм. Тухайлбал, Глобалчлал хэр гүнзгий явагдаж байгаа вэ? Ямар орнууд илүү их глобалчлагдаад байгаа вэ? Хамгийн бага глобалчлагдаад байгаа ямар орнууд байгаа вэ? Яагаад? зэрэг асуудлуудад хариулах шаардлага зайлшгүй урган гарч байна. Глобалчлалын шалгуур үзүүлэлтийн талаар хийсэн мэр сэр цөөхөн оролдлого байгаа хэдий ч тэд ихэвчлэн олон улсын худалдаа, хөрөнгө

---

\*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

оруулалтад анхаарч дэлхий нийтийн глобалчлалын бусад олон асуудлуудыг орхигдуулдаг. Энэхүү хийдлийг арилгаж, дээрхи асуултанд хариулт өгөх үүднээс олон улсын хэмжээнд нэр хүндтэй Кернегийн Гадаад бодлогын сэтгүүлийн газар хөгжингүй болон дэлхий дахинд шинээр үүсч буй гол гол зах зээлийн орнуудын интеграцлалын түвшинг тогтоох замаар глобалчлалын индексийг шинэчлэн боловсруулжээ. Глобалчлалын индексийг илүү бодитой болгохын тулд **мэдээллийн технологи, санхүү, худалдаа, улс төр, аялал жуулчлал, харилцаа холбооны** хөгжлийн үзүүлэлтүүдийг харьцуулан судалсан байна.

Бид Америкийн Гадаад бодлогын нийгэмлэгээс эрхлэн 2002 онд хэвлүүлсэн Кернегийн дээрхи судалгааны дүнг түүвэрлэн танилцуулж байна. Энэхүү судалгааны дүн глобалчлалын өнөөгийн үйл явц, чиг хандлагыг бодитой ойлгоход тус дөхөм үзүүлнэ гэдэгт найдна.

Судалгааны явцад тэд олон гайхалтай зүйлүүдийг олж илрүүлсэн байна. Тухайлбал, тэдний хийсэн судалгаагаар дэлхийн хамгийн илүү глобалчлагдсан орнуудын хүн амын орлого глобалчлалд бага ороод байгаа орнуудын хүн амын орлоготой харьцуулахад илүү тэгш хуваарилгдсан байна. Энэ нь хөгжиж буй орнууд глобалчлалын уршгаар улам ядуурч, тэдгээрийн хүн амын орлогын хуваарилалт улам тэгш бус болж түүнд түүх, эдийн засаг, нийгэм, боловсролын бодлого чухал нөлөөтэй гэж үзэж байсан нийтлэг үзэл бодлыг няцааж байна. Түүнээс гадна хамгийн их глобалчлагдсан орнуудад ихэнхдээ жижиг орнууд орсон байна. Учир нь жижиг орнууд илүү нээлттэй байж дотооддоо байхгүй бараа, үйлчилгээ, хөрөнгө олж авч байгаатай холбоотой. 2000 оны байдлаар Сингапур хамгийн их глобалчлагдсан орон болсон бөгөөд түүний дараагаар Нидерланд, Швед, Швейцар орж байв. Харин үүний эсрэгээр АНУ глобалчлагдсан орнуудын дунд 12 дугаар байранд орсон байна.

Мөн цөөхөн тохиолдлыг харгалзахгүй бол глобалчлалын индекс нь хамгийн өндөр орнуудын иргэд ихэнхдээ иргэний болон улс төрийн эрх илүү эдлэж байгаа нь судалгаагаар нотлогдсон байна. Түүнээс гадна ихэнхи глобалчлагдсан орнуудын төрийн албан хаагчдыг бодвол хаагдмал орнуудын төрийн албан хаагчид хээл хахуульд илүү автагддаг болох нь тогтоогдсон байна. Мөн интернет хэрэглэж байгаа байдлын талаарх янз бүрийн үзүүлэлтээрээ АНУ, Канад, Финлянд, Швед мэтийн Скандинавын орнууд бусад хөгжилтэй орнуудаас хол илүү гарч дэлхий дахинд интернет болон мэдээллийн технологийн хэрэглээний зааг ялгаа улам нэмэгдсээр байгаа гэсэн дүгнэлт хийжээ.

Глобалчлалын индексийн хоёр дахь чиглэл болгон дэлхийн интеграцчлалын байдлыг 2000 оны эцэс хүртэл авч үзжээ. Ингэхдээ хэд хэдэн чухал асуудалд урьд өмнөхөөс илүү их ач холбогдол өгч судалсан байна. **Нэгдүгээрт**, урьд өмнө авч үзэж байсан 50 орон дээр шинээр нэлээд хэдэн орныг нэмж оруулжээ. Тухайлбал, индекст шинээр Африк, Төв болон Зүүн Европ, Зүүн Азийн нэлээд орныг нэмснээр дэлхийн хүн амын 85 орчим хувь, дэлхийн бүтээгдэхүүний үйлдвэрийн 90 гаруй хувийг хамруулж судалсан байна. **Хоёрдугаарт**, шинэчлэгдсэн индекст улс орнуудын дипломат үйл ажиллагаа, олон улсын аюулгүй байдалд оролцож буй байдал зэргийг олон улсын байгууллагад гишүүнээр элссэн байдал, олон улсын энхийг сахих үйлст оруулж буй хувь нэмэр, тухайн оронд сууж буй дипломат төлөөлөгчдийн газрын тоо зэргээр хэмжих шинэ хэмжүүр буй болгожээ. **Гуравдугаарт**, дэлхий дахинд шинээр үүсэж буй нөхцөл байдал болон бид ямар ямар хүнд зорилтын ард гараад байгаа зэргийг илүү мэдрэх үүднээс хамгийн сүүлийн үеийн мэдээлэл ашигласан байна.

2000 онд дэлхийн эдийн засгийн өсөлт даруухан байсан хэдий ч олон үзүүлэлтээр дэлхий дахины интеграцчлал гүнзгийрсэн байна. Тухайлбал, дэлхийн барааны экспорт 2000 онд 12 хувиар өссөн бол үйлчилгээний худалдаа 6.1 хувиар өсч дээрх хоёр үзүүлэлтийг хамтад нь авч үзвэл өмнөх жилийнхээс 3 дахин өссөн байна. Дээрхийн нэгэн адил 2000 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт урьд өмнө байгаагүйгээр өссөн байна. Тухайлбал, гадаадын шууд хөрөнгө оруулалт 1999 онд 1.08 триллион ам.доллар байсан бол 2000 онд 1.27 триллион ам.доллар болтлоо өсчээ.

1990 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт дөнгөж 203 млрд ам.доллар байсан байна. Эдгээр хөрөнгө оруулалтын дийлэнх нь корпорациуд бусад орнуудын компанийг худалдан авах, түүнтэй нэгдэн нийлж, олон үндэсний корпораци байгуулах зэрэгтэй гол нь холбоотой аж. Нэгэн жишээ дурдахад 2000 онд Францын томоохон пүүсүүдийн ашиг орлогыг гадаадад болон дотоодод байрладаг салбаруудтай нь харьцуулж үзсэн байна. Судалгаанаас үзэхэд гадаадад буй салбарууд нь дотоодод буй салбаруудаасаа даруй хоёр дахин илүү их ашиг олсон байна. Энэ үзүүлэлт нь 1990 оны түвшингөөс даруй хоёр дахин их байна. Их Британи, Герман, Итали зэрэг орнуудын томоохон пүүсүүдийн гадаад худалдаа дунджаар дотоодын нийт худалдааны хэмжээтэй тэнцэж байна гэсэн судалгаа гарчээ.

XX зууны сүүлчийн арван жилд дэлхийн эдийн засаг ерөнхийдөө тогтвортой өссөн, шинэ зуунд шилжиж байгаа онцгой үйл явдалд зориулан зохион байгуулсан янз бүрийн арга хэмжээтэй холбогдон жуулчдын тоо эрс нэмэгдсэн байна. Дэлхийн жуулчдын тоо арван жилийн өмнө 457.2 сая байсан бол 2000 онд 698.8 саяд хүрсэн бөгөөд зорчигчид нэмэлт 50 сая аялал хийсэн байна. Дэлхийн бүх бүс нутгийн хувьд жуулчдын тоо нэмэгдсэн бөгөөд түүний дотор Ази, Номхон далайн бүс нутагт зорчих жуулчдын тоо ихээхэн нэмэгдсэн байна. Жуулчнаас гадна бусад зорилгоор зорчигсдын тоо ч нэмэгдсэн байна. Гол нь үнэ хямдарсантай холбогдон 2000 онд олон улсын телефон яриа байнга нэмэгдэж 10 тэрбум минутанд хүрчээ.

2000 онд интернетийн хэрэглээ 44 хувиар өссөн байна. Гэхдээ энэхүү өсөлт интернетийн бизнесийн бум болсон 1999 оны өсөлтийн 1/3-ээс бага байгаа аж. Зарим талаар энэхүү өсөлтийн удаашрал нь интернетийн бизнесийн удааширсантай холбоотой гэнэ. Тэгсэн ч гэсэн 2000 оны байдлаар 80 сая интернетийн шинэ хэрэглэгч нэмэгдсэн байна. Ерөнхий хандлагаас үзэхэд англи хэлнээс гадна бусад хэл интернетийн хэрэглээнд нэвтрэх төлөвтэй байгаа аж. Судалгаанаас үзэхэд интернетийг 192 сая англи хэлтэнгүүд хэрэглэж байгаа бол төрөлх хэл нь англи биш 211 сая хүн интернет хэрэглэж байгаа аж. Англи хэл интернетийн гол хэл хэвээр байгаа хэдий ч япон, хятад, герман хэлний хэрэглээ нэмэгдэж байгаа гэнэ. Ирэх онуудад испани хэлний хэрэглээ ч ихээхэн өсөх төлөвтэй аж.

Дээр дурдсанаас гадна улс төрийн харилцааны далайц хэмжээ удаан ч гэсэн байнга өсөн нэмэгдэж байгаа аж. 1995 оноос 2000 оны хооронд өндөр хөгжилтэй болон шинээр аж үйлдвэржсэн орнууд гадаадад нийт 344 элчин сайдын яамаа нээсэн байна. Зөвхөн Бангладеш, Сенегал, Турк, Венесуэль мэтийн хэдхэн орнуудад байгаа элчин сайдын яамны тоо цөөрсөн байна. Ази, Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны Форумд шинээр суудал эзэлсэн Перу, ОХУ, Вьетнам зэргийг оролцуулан олон улсын байгууллагын 342 суудалд шинэ гишүүн элссэн байна. НҮБ-ын энхийг сахиулах, улс орныг тохинуулах арга хэмжээ бага зэрэг цөөрсөн байна. Тухайлбал, 1995 онд 20 байсан бол 2000 онд 18 байжээ. Харин энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцогч орны тоо нэмэгдсэн байна. 2000 оны байдлаар дэлхийн 66 орон энхийг сахиулах үйлст цэрэг, иргэний цагдаа, мөнгө, эм болон тоног төхөөрөмжийн хандив оруулсан байна. Эдгээрээс Австри, Бангладеш, Канад, Дани, Финлянд, Франц, Ирланд, Итали,

Польш, Орос, Швед зэрэг янз бүрийн түвшний хөгжилтэй орнууд 2000 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конгоос эхлэн Зүүн Тиморт энхийг сахиулах НҮБ-ын үйл ажиллагаа хүртэлх энхийн үйл ажиллагааны хагасаас илүүд нь шууд хувь нэмрээ оруулсан байна.

Товчхондоо сүүлийн арван жилийн дэлхийн эдийн засгийн өсөлт, өсөн нэмэгдсэн улс төрийн харилцаа, хүмүүсийн зорчих хөдөлгөөн, мэдээлэл зэрэг нэмэгдснээс үүдэн 2000 онд дэлхий нийтийн интеграцлал дээд цэгтээ хүрсэн гэсэн дүгнэлт хийжээ. Ийм байдал дэлхийн улс орнуудын хооронд цаашид үргэлжилсэн хэвээр байх магадлал байгаа хэдий ч тийм баталгаа ч бас байхгүй юм. Глобалчлалд гүнзгий ороод байгаа орнууд мэдээж түүний нөлөөнд юунаас ч илүү татагдан орох нь мэдээж.

2000 оны индексээс үзэхэд жижиг орнууд тэдгээрийн томоохон хөрштэй харьцуулахад олон улсын интеграцлалд арай илүү орсон байна. Тухайлбал, 2000 оны индексээр Сингапур глобалчлалыг тэргүүлж байсан бол 2001 оны хувьд эдийн засгийнх нь өсөлт 1998 оноос эхлэн хурдаа аваад байгаа Ирланд орсон байна. 2000 оны хувьд Ирланд зургадугаар байр эзэлж байжээ.

Ирландын бизнесийг дэмжих бодлого болон англи хэлээр ярьдаг зэрэг давуу талууд нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндэс болсон аж. Энэ орон олон улсын хөрөнгө оруулалт, технологийн дэвшлийг өөртөө татах үүднээс корпорациудад ногдуулдаг татварын хэмжээг бууруулж/ Европын орнуудын дунд хамгийн бага/ дэд бүтцийг хөгжүүлэх, засгийн газрын ажлын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн Үндэсний Хөгжлийн Хөтөлбөр хүртэл боловсруулжээ. Түүнчлэн холбоо, банкны салбарын төрийн өмчийг хувьчилсан нь хөрөнгө оруулагчдад үлэмж таатай нөхцөл бүрдүүлсэн чухал үйл явдал болжээ. Мөн Еврогийн зонд орсон нь санхүүгийн хөрөнгийн урсгалыг чөлөөтэй болгож өгсөн байна. Энэ бүхэн нь Ирланд глобалчлалыг тэргүүлэгч орон болох үндсэн нөхцөл болсон байна.

Ирланд дэлхийн технологийн өндөр хөгжил, мэдээллийн технологийн үр шимийг ихээхэн хүртэж байгаа орны нэг. Ирланд анхнаасаа өндөр технологийг дэмжих бодлого явуулж байсан явдал өндөр технологийн ач холбогдол дэлхий дахинд эрс нэмэгдэхэд түүний үр шимийг хамгийн түрүүнд хүртэгч болсон байна. 2000 он гэхэд Микрософт, Интел, Гейтвэй Глобал Кроссинг зэрэг нь Ирландыг Европ дахь өөрсдийнхөө “гэр” болгосон юм. Эдгээр өндөр технологийн хөрөнгө оруулалт нь Ирландын гадаадын шууд хөрөнгө оруулалт

тогтвортой өсч байгаагийн гол шалтгаан юм. Гадаадын хөрнгө оруулалт Ирландад 1990-ээд оны дунд хүртэл жилд дунджаар 3 тэрбум ам.доллар байсан бол 2000 онд 20.5 тэрбум ам.доллар буюу нэг хүнд 5,500 ам.долларын хөрөнгө оруулалт ногдож байна. Харин Финляндад нэг хүнд 1,653 ам.доллар байдаг бөгөөд үүнээс Ирландынх даруй 3 дахин их байна.

Түүнээс гадна Ирланд нь олон улсын хувьцааны хөрөнгө оруулалтыг өөртөө татаж чадснаар олон улсын санхүүгийн нэг гол төв болоод байна. Ийм төрлийн хөрөнгийн урсгал нь 1996 оны байдлаар Ирландын үндэсний эдийн засгийн 1.6 хувийг эзлэж байв. 2000 оны байдлаар хувьцааны хөрөнгө оруулалтын өсөлт Ирландын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй нь харьцуулахад дэлхийд хамгийн өндөр хурдацтай өссөн байна. Энэ нь олон улсын банк, хөрөнгө оруулалтын сан, корпорацийн санхүү, даатгалын үйл ажиллагаагаараа дэлхийд тэргүүлдэг Дублиний Олон улсын Санхүүгийн Үйлчилгээний Салбар Төв Ирландад байгуулагдсантай холбоотой аж.

Ирланд нь бусад үзүүлэлтүүдээрээ ч гэсэн тэргүүлж байна. Тухайлбал, өсөн нэмэгдэж байгаа жуулчны үйлчилгээ, холбооны салбарын өндөр хөгжил нь энэ орныг олон улсын холбоо, түүний дотор интернет ашиглалтаар Европод тэргүүлэх орны нэг болгожээ.

Эдийн засгийн хэд хэдэн үзүүлэлтээс үүдэн 2001 онд Сингапур глобалчлагдсан орнуудын дунд гуравдугаар байранд оржээ. Сингапур дэлхийн худалдаанд эзлэх байр сууриараа томоохон орны нэг хэвээр байгаа хэдий ч дэлхий дахинд өсөн нэмэгдэж байгаа хувьцааны хөрөнгө оруулалтын давуу талыг өөртөө ашиглах тал дээр доголдсон байна. Сингапур хөрөнгийнхөө биржийг өөрчлөн байгуулсан нь зохих хэмжээний хөрөнгө өөртөө татаж, алс хэтдээ санхүүгийн төв болох чиглэлд зохих нөлөө үзүүлсэн хэдий ч бусад орнуудтай харьцуулахад санхүүгийн хөрөнгө өөртөө татах боломж нь хязгаарлагдмал гэдэг нь тогтоогдсон байна. Тухайлбал, 1998-2000 оны хооронд хувьцааны хөрөнгө оруулалт Ирландад 26 тэрбум ам.доллараар өссөн бол мөн хугацаанд Сингапурт дөнгөж 1.3 тэрбум ам.доллараар л өсчээ.

Гэсэн хэдий ч Сингапур нь бусад янз бүрийн үзүүлэлтүүдээрээ, ялангуяа холбоо, мэдээллийн технологийн хөгжлөөрөө ихээхэн хүчтэй хэвээр байна. Тухайлбал, нэг хүнд оногдох олон улсын яриагаараа Сингапур дэлхийд аль хэдийн тэргүүлэх болсон билээ. 2000 онд Сингапурын оршин суугчдын утсаар ярьсан дундаж хугацаа нь 2.5 хувиар нэмэгдэж, нэг хүнд оногдох зөвхөн гадаад руу ярьсан минут

400-д хүрсэн байна. /гадаадаас хүлээн авсан утасны яриа нэг хүнд 317 минут оногдож байна/

Интернетийн сүлжээний нэвтрэх чадварын хувьд АНУ, Канад тэргүүлж байна. 2001 оны нэгдүгээр сарын байдлаар АНУ-ын хүн амын 35 хувь, Канадын хүн амын 41 хувь нь интернет хэрэглэж байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтээрээ дээрх хоёр орон дэлхийд эхний 10 оронд багтаж байгаа буюу үндсэндээ Скандинавын орнуудын дараа орж байна. Гурван хүнд нэг интернетэд холбогдсон компьютер оногдож байгаа үзүүлэлтээрээ АНУ нь гурваас дээш тийм компьютер оногдож байгаа Швед, Норвег, Финлянд зэрэг Скандинавын орнууд, 10 –аас дээш хүн оногдож байгаа Их Британи зэргийг тэргүүлж байна. АНУ электрон худалдаа явуулж болох дэлхийн 118 мянган серверийн 77000-ийг эзэмшиж байна. Интернетийн мэдээллийн 95 хувь нь АНУ-ыг дамжин орж гарч байна.

2001 оны глобалчлалын индексээс үзэхэд интернетийн хэрэглээ, түүний хөгжлөөрөө Скандинавын орнууд Европын орнуудыг тэргүүлж байв. 2000 оноос Австрали, Шинэ Зеланд мэтийн далайн орнууд интернетийн холбоогоороо бүс нутгийн төв болон гарч ирж байна. 2000 онд Австралийн хүн амын 35 хувь нь интернет хэрэглэх болж АНУ-ыг гүйцэж түрүүлсэн бөгөөд Шинэ Зеланд хүн амд оногдох интернетэд холбогдсон компьютерийнхээ тоогоор дөрөвдүгээр байранд орсон байна. Австрали, Шинэ Зеланд нь хүн амыг интернетийн найдвартай үйлчилгээгээр хангаж байгаа үзүүлэлтээрээ дэлхийн орнуудын дунд эхний тавд оржээ. Скандинавын орнуудын хувьд интернет ихээхэн өндөр хөгжсөн явдал нь эдийн засгийн үсрэнгүй хөгжил, газар зүйн хувьд тусгаарлагдмал байдал, хүн амын тархай бутархай байршил зэргийг харгалзсан төрийн бодлого явуулсантай холбоотой.

Өнөөдөр глобалчлалын талаар ихээхэн хүчтэй өрнөж байгаа маргаан нь улс орнуудын хоорондын өрсөлдөөн татвар буурахад нөлөөлөх эсэх, гадаадын хөрөнгө оруулалт болон бусад олон улсын бизнесийн сонирхлыг татах үүднээс нийгмийн зардлыг багасгахад хүргэх эсэх зэрэг асуудлыг тойрон гарч байна. Зарим судлаачдын үзэж байгаагаар глобалчлалын нөлөөгөөр засгийн газрууд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх үүднээс татвараа багасгаснаас ажлын байр шинээр буй болгох, боловсрол, нийгмийн даатгал зэрэгт зарцуулах хөрөнгийн хэмжээ хумигдаж хүн амын амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Дээрх таамаглалыг шалгах үүднээс Кернегийн судалгааныхан орон бүрийн татварын хэмжээ, нийгмийн салбарт зориулж буй засгийн газрын зардлын талаархи Дэлхийн Банкны статистикийг авч үзээд түүнийг глобалчлалын индекстэй харьцуулж үзжээ. Тэдний хийсэн судалгаагаар татварын хэмжээ, нийгмийн зарлагын хэмжээ хоёр шууд хамааралтай байгаа боловч тэр хоёрын аль алин ч глобалчлалын индекстэй хамааралгүй болох нь тодорхой болжээ. Үнэн хэрэгтээ татварын хэмжээ ихээхэн глобалчлагдсан орнуудад ч өндөр байх тохиолдол байгаа хэдий ч нийгэмд зориулсан зардлын хэмжээ өөр өөр байна. Тухайлбал, Израйл, Чех зэрэг нь глобалчлалд хамрагдсан орнууд хэдий боловч татварын хэмжээ нь үндэсний эдийн засгийн үйлдвэрлэлийнх нь 40 гаруй хувийг эзлэж байна. Глобалчлалын индекст доогуур байр эзлэж байгаа Коломб, Индонез, Пакистан зэрэг орнуудад дээрхи орнуудаас ч илүү байна. Харин Швед, Финлянд зэрэг хамгийн их глобалчлагдаад байгаа орнуудад өндөр татварын нөлөөгөөр нийгэмд зориулж байгаа зардлынхаа хэмжээгээр дэлхийд тэргүүлж байна.

Сүүлийн жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалт өөртөө ихээхэн татаж байгаа Скандинавын орнуудын жишээнээс үзэхэд татварын өндөр хэмжээ гадаадын хөрөнгө оруулалтыг холдуулдаг гэсэн ойлголтыг нотлохгүй байгаа аж. Гадаадын хөрөнгө оруулагчид гол нь эдийн засгийн хөгжлийн төлөв, дэд бүтцийн хөгжил, хүн амын боловсролын түвшин болон бусад гол үзүүлэлтүүдэд ихэвчлэн анхаардаг болох нь тогтоогдсон байна.

1995 оноос дэлхийн нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд хамтарч, дэлхийн нийгэм, соёл, улс төрийн өөрчлөлтийн талаар судалгаа хийж эхэлжээ. Эрдэмтэд, судлаачдын энэ томоохон баг дэлхийн хүн амын 80 гаруй хувийг хамарсан 65 оронд судалгаа хийсэн байна. Эрдэмтэд хувь хүмүүсийн амьдралдаа сэтгэл ханамжтай байгаа эсэх, санхүүгийн баталгаа зэргээс эхлэн орон нутгийн засаг захиргаа, хүрээлэн буй орчныг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх хүртэл янз бүрийн хэдэн зуун санал асуулгаас бүрдсэн судалгаа хийжээ.

Судалгаанд хамрагдсан хүмүүсээс “аз жаргалтай” амьдарч байгаа эсэх талаар асуулга явуулж түүнийг тухайн орны глобалчлалын индекстэй нь харьцуулж үзэхэд глобалчлал нь хүмүүст аз жаргал авч ирж байна гэж үзэх үндэсгүй байгаа боловч Ирланд, Дани, Их Британи зэрэг глобалчлагдсан орнуудад амьдарч буй хүмүүс амьдрал илүү сайхан болно гэсэн итгэл дүүрэн, сэтгэл хангалуун аж төрж байна.

Харин дэлхий нийттэй холбогдоогүй тусгаарлагдмал орнуудын хүмүүс гэж үзэхгүй байгаа нь тодорхой харагдсан байна.

Хэдийгээр глобалчлагдсан ихэнхи орнууд баян чинээлэг байгаа нь үнэн боловч глобалчлал, баялаг, аз жаргалын хоорондын холбоо ойлгомжтой байна. Тухайлбал, судлаачдын тодорхойлсноор аз жаргал нь нэг хүнд ногдох орлогын хэмжээгээр эдийн засгийн хөгжлийн тодорхой түвшин хүртэл хэмжигдэж байгаа бөгөөд хөгжлийн тодорхой түвшнөөс цааш аз жаргалын тухай ойлголт өөр болж байна.

2000 оны хувьд дэлхийн интеграцчлалд ихээхэн ахиц гарсан хэдий ч тоо баримтыг нарийн судлахад хөгжиж буй орнуудын байдал тэр бүр адил биш байна. Тухайлбал, интернетийн хэрэглээ өндөр хөгжилтэй орнуудад ихээхэн хурдацтай нэмэгдэж байгаа хэдий ч хөгжиж буй орнуудын хувьд байдал өөр байна. Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллагын тооцоолсноор 2000 оны байдлаар интернетэд холбогдсон компьютерийн 95.6 хувь энэ байгууллагын гишүүн орнуудад ногдож байгаа ажээ. Үлдсэн хэсгийн талаас илүү хувь нь Хонконг, Сингапур, Тайванд ногдож үлдсэн өчүүхэн хэсэг нь дэлхийн бусад орнуудад ногдож байна. 2001 оны эцэс гэхэд Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллагын гишүүн орнууд 1000 хүн тутамдаа интернетэд холбогдсон 100 компьютер ногдохоор байгаа бөгөөд тэгвэл дэлхийн бусад орнуудын хувьд 1000 хүн тутамдаа 1 компьютертэй болвол дээдийн заяа болох төлөвтэй байна.

Ийнхүү мэдээллийн технологийн хэрэглээнд гарч буй ялгаа зааг нь шинээр зах зээлд шилжиж буй орнуудын хувьд дэлхийн интеграцчлалд гүнзгий нэвтрэхэд нь илүү бэрхшээл учруулах төлөвтэй.

Глобалчлалаас ухрах үйл явц аль ч бүс нутагт гараагүй байгаа хэдий ч зарим орнууд, тухайлбал, Ботсвана, Египет, Перу, Саудын Арав зэрэг нь бусад орнуудтай харьцуулахад дэлхий дахинд бараа, хөрөнгө, хүмүүс, үзэл бодлын чөлөөт урсгал, технологийн хөгжлийн хурдцыг гүйцэж чадахааргүйгээр дэлхий ертөнцтэй интеграцчлах үйл явцаа сааруулж байна. Шинээр аж үйлдвэржиж байгаа орнууд шинээр 265 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт өөртөө татсан хэдий ч нийт хөрөнгө оруулалтын урсгалд тэдгээрийн эзлэх хувийн жин дөрвөн жил дараалан буурсан байна. Тухайлбал, 1997 онд 43 хувь буурсан бол дараагийн жилүүдэд жил бүр 30 хувь, 23 хувь, 21 хувиар тус тус буурсан байна. Африкийн орнууд хэдэн сая

шинэ жуулчдыг өөртөө татсан боловч дэлхийн нийт жуулчдын урсгалын дөнгөж 4 хувийг л эзэлсэн байна.

Түүнээс гадна зарим бүс нутгийн хувьд дэлхийн эдийн засагтай хараахан гүйцэд интеграцчлагдаагүй байна. Тухайлбал, Африкийн орнуудын эдийн засгийн интеграцчлалын түвшин сүүлийн 6 жилийн байдлаар нэмэгдэж хасагдсаар ирсэн байна. Энэ нь эдгээр орнууд голлон дэлхийн зах зээлтэй холбогдож байгаа нефть, түүхий эдийн экспортын үнэ дэлхийн зах зээл дээр нэг үе нэмэгдэж, нэг үе унан хэлбэлзэж байсантай холбоотой гэж судлаачид үзсэн байна.

Өнөөдөр бид терроризмын уршгаас Нью Йоркийн хоёр өндрийн урьд байсан байдал түүний үгүй болсон зургийг цөмөөр хараад байгаа билээ. 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын улмаас глобалчлалын үйл явц хэдий хэмжээний хохирол амссаныг хэлэхэд эдүгээ хэцүү.

Гэсэн хэдий ч улс орнууд терроризмын нөлөөнөөс үүдэн хил хязгаар, аюулгүй байдлын хамгаалалтаа хүчтэй болгож байна. Үүнтэй холбогдсон төсөв, зардал ч асар их өсөх болов. Терроризмын улмаас хүн ардын өсөн нэмэгдэж байгаа түгшүүр, түүнчлэн улс орнуудын хил, гаалийнхны зорчигчдод тавих болсон шинэ хязгаарлалт зэрэг нь жуулчдын хөдөлгөөнд чөдөр болж ч болзошгүй боллоо. Дэлхийн жуулчдын тоо сүүлийн 50 жилд анх удаа буурахад хүрээд байна.

Хөрөнгө оруулагчид аль ч оронд хөрөнгө оруулалт хийлээ гэсэн ихээхэн болгоомжтой хандах боллоо. Хөрөнгө оруулагчид хамгийн гол нь аюулгүй байдалд илүү анхаарснаас үүдэн хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр хөгжилтэй орнуудад буурч, хувьцааны хөрөнгө оруулалт 1980-аад оноос хойш байгаагүй хэмжээгээр багасч болзошгүй байдал ажиглагдаж байна.

Дээрх хандлагууд дэлхийн эдийн засагтай нягт интеграцчлагдсан орнуудад харилцан адилгүй нөлөөлөх төлөвтэй. Тухайлбал, Ирландын хувьд жуулчны салбар ихээхэн хохирол амсаж байна. 2000 онд жуулчны салбарын өсөлт 11 хувьтай байсан бол 2001 онд 3 хувь болтлоо буурсан байна. Жижиг эдийн засагтай, гадаад худалдаанд голлон тулгуурласан Сингапурын хувьд глобалчлалын зогсонги байдал нөлөөлж эхлээд байна. Сингапурын экспорт, импорт 1965 онд тусгаар тогтносноос хойш байгаагүй хэмжээгээр буурч байна. Дэлхийн интеграцчлалтай гадаад худалдаагаар холбогдсон бусад орнууд, тухайлбал, Малайз, Словак, Панам, Тайланд, Филиппин зэрэг орнууд ч ийм байдалд автагдаж болзошгүй гэж судлаачид таамаглаж байна. Бусад орнууд, тухайлбал, олон улсын хувьцааны хөрөнгө,

гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалаас ихээхэн хамаарах Ирланд, Нидерланд, Финлянд, Испани, тэр ч бүү хэл АНУ ч глобалчлалын өрнөлийг хадгалахын төлөө тэмцэхэд хүрч магадгүй байна.

Дэлхийн эдийн засгийн хөгжил удааширсан хэдий ч глобалчлалын бусад хандлага урагш тэмүүлсэн хэвээр байх төлөвтэй. Үүнд өсөн нэмэгдэж байгаа дэлхийн глобалчлалын салшгүй нэгэн хэсэг болох хил дамнасан хувь хүмүүсийн харилцааг дурдаж болох юм. Аялах явдал хэцүү төвөгтэй болох тэр хэмжээгээр хүмүүсийн хоорондоо утас, интернетээр харилцах явдал нэмэгдэнэ. Олон улсын Телефон Холбооны Байгууллагын тооцоолсноор телефон яриа жилд дунджаар 20 хувь буурч байгаа бөгөөд 1997 оноос хойш жилд дунджаар 10 тэрбум минутаар нэмэгдэж байсан олон улсын телефон яриа 9 дүгээр сарын 11-ний үйл явдлаас үүдэн буурах төлөвтэй байгаа аж. Үнэн хэрэгтээ эдүгээ АНУ руу ярьж байгаа телефон яриа дунджаар минут нь 50 центээс бага байна. Энэхүү үзүүлэлт нь олон орнуудын дотоодын холын зайн ярианы тарифаас ихгүй байна. Интернетийн хэрэглээний хувьд ч ялангуяа, Хятад, Энэтхэг мэтийн хөгжиж буй орнуудад урьд өмнө байгаагүй хэмжээгээр нэмэгдэж байна. Цэрэг, дипломат болон эдийн засгийн талбар дахь терроризмын эсрэг тэмцэл олон улс хоорондын харилцаа холбоо улам нэмэгдэхэд нөлөөлж байна.

Дэлхийн эдийн засгийн хувьд ч урагш тэмүүлэх хандлага зогсоно гэж хэлэх үндэс алга байна. Улс орнууд эдийн засгийн зогсонги байдлаасаа гарахын тулд цаашид ч дэлхий нийтийн интеграцлал руу тэмүүлэх чиг хандлага давамгайлж буй аж. Тухайлбал, хоёр жилийн өмнө Сиегтлд болсон үйл явдлаас үүдэн Дэлхийн Худалдааны Байгууллагын яриа хэлэлцээ зогссон боловч төлөөлөгчид Катарт болсон уулзалтынхаа үеэр аж үйлдвэр, хөдөө аж ахуйн өргөн хүрээтэй бүтээгдэхүүнд тавьж байсан худалдааны саад тотгорыг арилгахад чиглэсэн яриа хэлэлцээг шинээр эхлэхээр тохирч чадсан нь үүнийг гэрчилж байна.

Глобалчлал нь эдийн засгийн, улс төрийн, нийгмийн бусад аливаа үйл явцын нэгэн адил янз бүрийн эрсдэл, түүний дотор аж ахуйн тогтворгүй байдалтай үнэхээр тулгарч болохыг үгүйсгэхийн аргагүй. Ингэхдээ дэлхийн эдийн засаг нь үндэснийхийг бодвол “хөгжил цэцэглэлт-хямрал” гэсэн орчлын нилээд эрс огцом өөрчлөлтөд автдаг. Ийм үед шинэ нөхцөлд маш хурдан дасан зохицож, тэсч гарах бүхий л арга замыг сүйхээлж чадсан нь “хожиж”, тухайн нөхцөлд дасан зохицож

чадаагүй юмуу ингэхийг хүсээгүй нь “хохирно”. Глобалчлалын үйл явц зохицуулалттай хяналтад тийм амар зохицдоггүй.

Глобалчлалд нийгмийн гажуудлыг арилгадаг ид шидийн хүч мэтээр хандаж болохгүй. Глобалчлал бол онолоор бичигдсэн азын шоо биш билээ.

### **Ашигласан эх сурвалж:**

1. Globalization's Last Hurrah. Foreign Policy Assosiation /<http://www.Globalpolicy.org/>
2. Joseph Stiglitz. Thanks for Nothing-Atlantic Monthly, October, 2001.
3. Joseph Kahn. The World's Economic slide Together into Recession-New York Times, November 25, 2001.